



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2026/040/НА-СТА-ТШЗ

| | |
|--|---|
| <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Дорнод аймаг</p> <p>2026 он</p> | <p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026-02-05 № 296
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Г.АЛТАНТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2125020279

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэг нь 2025 онд 5 зорилт, 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" буюу 81.6 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б БОЛОРТУУЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|------------|---|--------------------------------|--------------------------------|
| | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>122,272,069.72</u> | <u>76,409,589.84</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 87,530,863.52 | 19,801,408.64 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 87,530,863.52 | 19,801,408.64 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 87,530,863.52 | 19,801,408.64 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 34,741,206.20 | 56,608,181.20 |
| 354 | Хангамжийн материал | 34,741,206.20 | 56,608,181.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,159,760.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 3,047,450.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 29,533,996.20 | 56,608,181.20 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,110,030,843.43</u> | <u>1,080,991,517.87</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,110,030,843.43 | 1,080,991,517.87 |
| 392 | Биет хөрөнгө | 1,050,030,843.43 | 1,020,991,517.87 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,141,733,318.00 | 1,142,493,318.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (152,993,552.76) | (183,979,116.60) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 70,647,535.00 | 77,101,505.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (29,228,861.46) | (34,890,961.38) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 56,176,297.05 | 43,178,572.05 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (53,817,138.04) | (40,114,853.48) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 73,825,560.00 | 77,701,560.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (56,312,314.36) | (60,498,505.72) |
| 393 | Биет бус хөрөнгө | 60,000,000.00 | 60,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,167,600.00 | 1,167,600.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,167,600.00) | (1,167,600.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 60,000,000.00 | 60,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,232,302,913.15</u> | <u>1,157,401,107.71</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,232,302,913.15</u> | <u>1,157,401,107.71</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,232,302,913.15 | 1,157,401,107.71 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 779,038,980.86 | 779,038,980.86 |
| 51101 | Өмч: - төрийн | 779,038,980.86 | 779,038,980.86 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (24,437,103.07) | (99,338,908.51) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (24,437,103.07) | (8,161,378.07) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (91,177,530.44) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 477,701,035.36 | 477,701,035.36 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>1,232,302,913.15</u> | <u>1,157,401,107.71</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 994,614,372.55 | 1,089,384,700.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 35,320,872.55 | 15,358,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 35,320,872.55 | 15,358,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 33,890,272.55 | 12,470,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 1,430,600.00 | 2,888,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 959,293,500.00 | 1,074,026,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 913,664,500.00 | 1,014,803,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 913,664,500.00 | 1,014,803,800.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 45,629,000.00 | 59,222,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,629,000.00 | 59,222,900.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,008,927,898.61 | 1,180,562,230.44 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,008,927,898.61 | 1,180,562,230.44 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,008,918,098.61 | 1,172,643,049.13 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 719,443,953.00 | 856,007,551.08 |
| 210101 | Үндсэн цалин | 506,845,350.00 | 570,398,938.31 |
| 210102 | Нэмэгдэл | 180,036,673.00 | 228,393,283.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 26,265,000.00 |
| 210104 | Урамшуулал | 32,561,930.00 | 30,950,329.77 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 87,449,956.53 | 101,754,773.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,785,763.38 | 70,124,497.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,213,344.39 | 8,945,154.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,496,520.70 | 4,203,572.24 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,957,118.75 | 3,666,627.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,997,209.31 | 14,814,921.64 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 41,529,000.00 | 50,032,178.69 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,497,858.08 | 11,258,624.31 |
| 210302 | Түлш, халаалт | 20,759,961.92 | 24,871,014.38 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,271,180.00 | 13,902,540.00 |
| 2105 | Нормативт зардал | 88,645,571.00 | 88,469,980.00 |
| 210502 | Хоол, хүнс | 88,645,571.00 | 88,469,980.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 740,200.00 | 9,999,640.00 |
| 210604 | Урсгал засвар | 740,200.00 | 9,999,640.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 143,000.00 | 2,289,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 143,000.00 | 2,289,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 70,966,418.08 | 64,089,125.56 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,162,850.00 | 16,272,430.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,776,000.00 | 1,999,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 51,027,568.08 | 45,817,295.56 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,800.00 | 7,919,181.31 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 7,870,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 7,870,100.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 9,800.00 | 49,081.31 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,800.00 | 49,081.31 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (14,313,526.06) | (91,177,530.44) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (14,313,526.06) | (91,177,530.44) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 959,293,500.00 | 1,074,026,700.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 959,293,500.00 | 1,074,026,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 913,664,500.00 | 1,014,803,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 913,664,500.00 | 1,014,803,800.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 45,629,000.00 | 59,222,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,629,000.00 | 59,222,900.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 967,530,952.53 | 1,138,856,184.88 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 967,530,952.53 | 1,138,856,184.88 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 967,521,152.53 | 1,130,937,003.57 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 719,882,925.00 | 856,007,551.08 |
| 210101 | Үндсэн цалин | 507,284,322.00 | 570,398,938.31 |
| 210102 | Нэмэгдэл | 180,036,673.00 | 228,393,283.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 26,265,000.00 |
| 210104 | Урамшуулал | 32,561,930.00 | 30,950,329.77 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 87,449,956.53 | 101,754,773.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,785,763.38 | 70,124,497.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,213,344.39 | 8,945,154.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,496,520.70 | 4,203,572.24 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,957,118.75 | 3,666,627.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,997,209.31 | 14,814,921.64 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 41,529,000.00 | 49,174,178.69 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,497,858.08 | 11,258,624.31 |
| 210302 | Түлш, халаалт | 20,759,961.92 | 24,013,014.38 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,271,180.00 | 13,902,540.00 |
| 2105 | Нормативт зардал | 88,645,571.00 | 88,469,980.00 |
| 210502 | Хоол, хүнс | 88,645,571.00 | 88,469,980.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,090,200.00 | 9,999,640.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,090,200.00 | 9,999,640.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,543,000.00 | 2,987,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,543,000.00 | 2,987,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,380,500.00 | 22,543,080.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,980,100.00 | 17,140,080.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,400,400.00 | 5,403,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,800.00 | 7,919,181.31 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 7,870,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 7,870,100.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 9,800.00 | 49,081.31 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,800.00 | 49,081.31 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (8,237,452.53) | (64,829,484.88) |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 2,899,970.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 2,899,970.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 2,899,970.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 2,899,970.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | = | (2,899,970.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (8,237,452.53) | (67,729,454.88) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 95,768,316.05 | 87,530,863.52 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 87,530,863.52 | 19,801,408.64 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|------------------------|--|
| 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 779,038,980.86 | 477,701,035.36 | (24,437,103.07) | 1,232,302,913.15 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 16,275,725.00 | 16,275,725.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 779,038,980.86 | 477,701,035.36 | (8,161,378.07) | 1,248,578,638.15 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (91,177,530.44) | (91,177,530.44) |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 779,038,980.86 | 477,701,035.36 | (99,338,908.51) | 1,157,401,107.71 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|-----------------------|---|-------------------------|-------------------------|------------------------|
| 11000 | Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл | - | 87,530,863.52 | (87,530,863.52) |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,100,476,900.00 | 1,082,533,254.88 | 17,943,645.12 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,100,476,900.00 | 1,082,533,254.88 | 17,943,645.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,065,454,100.00 | 1,049,220,104.88 | 16,233,995.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 858,183,600.00 | 856,007,551.08 | 2,176,048.92 |
| 210101 | Үндсэн цалин | 561,118,400.00 | 570,398,938.31 | (9,280,538.31) |
| 210102 | Нэмэгдэл | 272,674,700.00 | 228,393,283.00 | 44,281,417.00 |
| 210103 | Унаа болон хоол | - | 26,265,000.00 | (26,265,000.00) |
| 210104 | Урамшуулал | 24,390,500.00 | 30,950,329.77 | (6,559,829.77) |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 106,558,800.00 | 101,754,773.80 | 4,804,026.20 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 72,283,000.00 | 70,124,497.83 | 2,158,502.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,568,900.00 | 8,945,154.45 | (376,254.45) |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,284,500.00 | 4,203,572.24 | 80,927.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,284,500.00 | 3,666,627.64 | 617,872.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,137,900.00 | 14,814,921.64 | 2,322,978.36 |
| 2105 | Нормативд зардал | 96,885,100.00 | 88,469,980.00 | 8,415,120.00 |
| 210502 | Хоол хүнс | 96,885,100.00 | 88,469,980.00 | 8,415,120.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,826,600.00 | 2,987,800.00 | 838,800.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 3,826,600.00 | 2,987,800.00 | 838,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,152,700.00 | 25,443,050.00 | 1,709,650.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,083,300.00 | 20,040,050.00 | 43,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн | 7,069,400.00 | 5,403,000.00 | 1,666,400.00 |

| | | | | |
|--------|--|-------------------------|-------------------------|------------------------|
| | дадлага хийх | | | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,870,100.00 | 7,870,100.00 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,870,100.00 | 7,870,100.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,870,100.00 | 7,870,100.00 | - |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,100,476,900.00 | 1,014,803,800.00 | 85,673,100.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,100,476,900.00 | 1,014,803,800.00 | 85,673,100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,021,122,900.00 | 1,014,803,800.00 | 6,319,100.00 |
| | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 79,354,000.00 | - | - |
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 79,354,000.00 | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 87,530,863.52 | (87,530,863.52) |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 19,801,408.64 | (19,801,408.64) |

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|-----------------------|---|----------------------|----------------------|------------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 59,222,900.00 | 59,173,818.69 | 49,081.31 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 59,222,900.00 | 59,173,818.69 | 49,081.31 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 59,222,900.00 | 59,173,818.69 | 49,081.31 |
| 2103 | БАЙР АШИГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ | 49,222,900.00 | 49,174,178.69 | 48,721.31 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,645,200.00 | 11,258,624.31 | (613,424.31) |
| 21302 | Түлш халаалт | 26,411,800.00 | 24,013,014.38 | 2,398,785.62 |
| 21303 | Цэвэр, бохир ус | 12,165,900.00 | 13,902,540.00 | (1,736,640.00) |
| 2106 | ЭД ХОГШИЛ, УРСГАЛ ЗАСВАРЫН ЗАРДАЛ | 10,000,000.00 | 9,999,640.00 | 360.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 9,999,640.00 | 360.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 49,081.31 | - |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 59,222,900.00 | 59,222,900.00 | - |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17.3 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэж аудитын явцад залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан 0.6 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", "Санхүүгийн тайлангийн толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэж залруулав.

- Бараа материал дансанд бүртгэлтэй 6.9 сая төгрөгийн бараа материалын ангиллыг өөрчилж залруулав. Энэ нь "УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", "Санхүүгийн тайлангийн толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй тул залруулав.
- Цалин нийт зардал, нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлангийн тайлагнасан дүнг 9.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шалгуур журмын 4.1.3-т "Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам болон УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх" 4.1.5.Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх" гэсэнтэй нийцэхгүй байсныг залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 7,358.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,337.5 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөв.

Аудитаар нийт 7.3 сая төгрөгийн зөрчил² 4 илэрснээс 7.3 сая төгрөгийн 3 албан шаардлага, 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

3.1 Албан шаардлага

1. Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг тайлант хугацаанд гүйцэтгэлээр 2.7 сая төгрөгөөр худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих гэж заасантай нийцэхгүй байна.
2. Хүүхдийн хоолны зарцуулалтад биет горим хэрэгжүүлэхэд /2026.02.02/ хүүхдийн ирцийн дэвтэр хөтлөөгүй, хүнсний ул мөрийн дэвтэр хөтлөөгүй, тогоочийн захиалгын хуудас байхгүй учир хоолны цэс дээрх орцтой тохирч байгааг тулгах боломжгүй, технологи картад тухайн өдрийн хоолны карт байхгүй, өндөг лаазалсан бүтээгдэхүүнийг зориулалтын бус газарт хадгалж байсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих гэж заасантай нийцэхгүй байна.
3. Дээд шатны байгууллагын баталсан орон тооны жишиг нормд тусгагдаагүй архив бичиг хэргийн албан тушаалын 1 хүнд хавсран гүйцэтгэн цалин 4.6 сая төгрөгийг олгосон нь БШУС, СС-ын 2024 оны А/85/34 тушаалын 1 дүгээр хавсралт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих гэж заасантай нийцэхгүй байна.
 4. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны тэмдэглэл ирүүлээгүй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг гишүүн тус бүр баталгаажуулаагүй, 30.9 сая төгрөгийн гэрээнд тусгаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.1-д “Гэрээний үнэ, 39.3.2-т Гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл”, 39.3.2-т “Гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл,” 47 дугаар зүйлийн 47.3-т “Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина”, 48.2.9-т “энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах”, 48 дугаар зүйлийн 48.4.6-д “Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл зөвлөмж”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг мөрдөөгүй байна.
 5. Өмнөх аудитаар илэрсэн худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлийг давтан гаргасанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | /мянган төгрөгөөр/ | | | | | |
|---|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----|--------------------|-----------------|--------------|--|---------|--|
| | | | | | | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| ҮХ-н шинжийг агуулсан хөрөнгийг БМ-ын дансанд бүртгэсэн | 1 | 648,0 | | | | | 1 | 648,0 | | | | |
| БМ-ын ангилал зөрүүтэй бүртгэлийг зассан | 1 | 6,880.0 | | | | | 1 | 6,880.0 | | | | |
| Цалин, НД, ХХОАТ-ын тайлангийн зөрүү | 1 | 9,766.4 | | | | | 1 | 9,766.4 | | | | |
| Дүн | 3 | 17,295.2 | | | | | 3 | 17,295.2 | | | | |

Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | |
|---|-------------|----------------|---------------|-----|-----------------|----------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|--|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн | |
| Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бараануудыг тайлант хугацаанд гүйцэтгэлээр худалдан авсан | 1 | 2,705.4 | | | 1 | 2,705.4 | | | | | | | |
| Хүүхдийн хоолны зарцуулалтад биет горим хэрэгжүүлэхэд /2026.02.02/ хүүхдийн ирцийн дэвтэр хөтлөөгүй, хүнсний ул мөрийн дэвтэр хөтлөөгүй, тогоочийн захиалгын хуудас байхгүй | 1 | | | | 1 | - | | | | | | | |
| Дээд шатны байгууллагын баталсан орон тооны жишиг нормд тусгагдаагүй архив бичиг хэргийн албан тушаалд хавсран гүйцэтгэн цалин олгосон | 1 | 4,652.6 | | | 1 | 4,652.6 | | | | | | | |
| Өмнөх оны аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой албан шаардлага хүргүүлж байсан алдаа зөрчлийг давтан гаргасан байна. | 1 | - | | | | | | | 1 | | | | |
| Дүн | 4 | 7,358.0 | | | 3 | 7,358.0 | | | | 1 | - | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | |
|--|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|--|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн | |
| Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил. | | | | | | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны тэмдэглэл ирүүлээгүй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг гишүүн тус бүр баталгаажуулаагүй, хүнсний материал/ жимс, гурил гурилан бүтээгдэхүүн, бусад хүнс/ худалдан авах гэрээг байгуулахдаа нийлүүлэх хүнсний барааны жагсаалт, нэгжийн үнийг хавсаргаагүй, тухайн багцын төсөвт өртгийг /гэрээний үнэ/ гэрээнд тусгаагүй. | 1 | 30,887,0 | | | 1 | 30,887,0 | | | | | | | |
| Дүн | 1 | 30,887,0 | | | 1 | 30,887,0 | | | | | | | |